ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Ховд аймгийн Манхан сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2023/139/НА/-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2023 он | Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Хоо өрлөгийн үрс - Аудит ХХК<br>Аудитор: А.Оюундэлгэр<br>Утас: 99306289<br>цахим хаяг: a_oyund@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
**3.5.1 Төсвийн төлөвлөлт** ........ 13
**3.5.2 Төсвийн гүйцэтгэл** ........ 13
**3.5.3 Нэмэлт төсөв** ........ 13
**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 14
**4.1 Ерөнхий зүйл** ........ 14
**4.2 Материаллаг байдал** ........ 14
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 14
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 14
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 14
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 15
**4.5.1 Завсрын аудитын талаар** ........
**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн** ........ 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 15
5.1 Залруулсан алдаа ........ 15
*Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй*
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БШУГ | Боловсрол шинжлэх ухааны газар |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.14 № 02/33

танай ____________-ны №____________-т

МАНХАН СУМЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ч.ЭНХТӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Манхан сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Манхан сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮБД-4 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дүгаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг** Тус сургууль нь 2022 онд нийт 680 хүүхэд сургах хүчин чадалтайгаас гүйцэтгэлээр 718 хүүхэд сургуулийн боловсролд хамруулж биелэлт 105.5 хувьтай байна.

021020239

Тус байгууллага нь тайлант онд  4  зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 97.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. “

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **159,771,193** | **150,030,444** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | **2,190,057** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | | 2,190,057 |
| 3121 | Төгрөг | | 2,190,057 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 2,190,057 |
| **33** | **АВЛАГА** | **15,835,974** | - |
| 333 | Татаас, санхүүжилтийн авлага | 2,530,699 | |
| 335 | Бусад авлага | 13,305,275 | |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 13,037,275 | |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 268,000 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **143,935,219** | **147,840,387** |
| 351 | Түүхий эд материал | 31,089,287 | 30,633,387 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 30,296,487 | 30,606,487 |
| 3513 | Эм боох материал | 792,800 | 26,900 |
| 354 | Хангамжийн материал | 112,605,933 | 116,967,000 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 904,500 | 190,500 |
| 3542 | Аж ахуйн материал | 3,670,410 | 2,952,000 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | 703,000 | 650,000 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 2,000,000 | 434,000 |
| 3545 | Барилгын засварын материал | 258,000 | 258,000 |
| 3546 | Хүнсний материал | 17,028,645 | 19,806,174 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 88,041,378 | 92,676,326 |
| 356 | Мал амьтад | 240,000 | 240,000 |
| II | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,372,813,501** | **1,400,030,070** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,372,813,501** | **1,400,030,070** |
| 392 | Биет хөрөнгө | 1,305,963,501 | 1,333,262,570 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,422,836,697 | 1,442,836,697 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -255,743,402 | -339,737,557 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 2,000,000 | 2,000,000 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -466,667 | -866,667 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 238,514,486 | 335,035,852 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -213,886,560 | -227,359,974 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 190,911,298 | 207,739,235 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -136,542,628 | -148,789,347 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 17,200,000 | 17,200,000 |
| 39217 | Ном | 41,140,278 | 45,204,330 |
| 393 | Биет бус хөрөнгө | 66,850,000 | 66,767,500 |
| 39301 | Програм хангамж | 330,000 | 330,000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -220,000 | -302,500 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 66,740,000 | 66,740,000 |
| III | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,532,584,695** | **1,550,060,514** |
| IV | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00** | **3,447,992** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **00** | **3,447,992** |
| 413 | Өглөг | 00 | 3,447,992 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00 | 38,381 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00 | 867,711 |
| 4136 | Бусад өглөг | 00 | 2,541,900 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 00 | 1,617,100 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00 | 924,800 |
| V | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,532,584,695** | **1,546,612,521** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,532,584,695** | **1,546,612,521** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,267,801,958 | 1,267,801,958 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,201,061,958 | 1,201,061,958 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 66,740,000 | 66,740,000 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -713,197,465 | -699,169,638 |

| | | | |
|---|---|---|---|
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | -713,197,465 | -713,197,465 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | 00 | 14,027,827 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 977,980,202 | 977,980,202 |
| VI | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,532,584,695** | **1,550,060,514** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/ төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,340,867,776** | **1,799,055,099** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 11,283,766 | 82,850,300 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 11,283,766 | 82,850,300 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11,283,766 | 5,411,100 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00 | 3,971,100 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00 | 1,440,000 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 11,283,766 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 00 | 72,980,355 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 00 | 4,458,845 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,329,584,010** | **1,716,204,799** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,148,828,000 | 1,410,444,500 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00 | 1,410,444,500 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,148,828,000 | 00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 31,119,710 | 4,246,699 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,230,999 | 00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,000,000 | 00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,888,711 | 00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00 | 4,246,699 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 149,636,300 | 301,513,600 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 149,636,300 | 301,513,600 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,430,667,285 | 1,785,027,273 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,430,667,285 | 1,785,027,273 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,372,460,317 | 1,712,198,763 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 937,243,886 | 1,087,922,999 |
| 210101 | Үндсэн цалин | 637,652,980 | 1,087,922,999 |
| 210102 | Нэмэгдэл | 228,701,805 | 00 |
| 210104 | Урамшуулал | 70,889,101 | 00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 122,956,668 | 136,387,110 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,005,782 | 93,539,359 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,511,040 | 10,927,918 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,544,993 | 8,715,454 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,800,625 | 2,098,500 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,094,228 | 21,105,879 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 147,041,876 | 243,773,711 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,660,876 | 10,780,711 |
| 210302 | Түлш, халаалт | 138,311,000 | 232,393,000 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 70,000 | 600,000 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,942,413 | 8,788,790 |
| 210401 | Бичиг хэрэг | 747,500 | 2,256,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,146,805 | 6,532,790 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 25,000 | 00 |
| 210404 | Ном, хэвлэл | 105,250 | 00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000 | 00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 855,900 | 00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,001,958 | 00 |
| 2105 | Нормативт зардал | 31,302,445 | 63,065,511 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,047,900 | 1,086,050 |
| 210502 | Хоол, хүнс | 24,273,645 | 61,979,461 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,980,900 | 00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,315,700 | 00 |
| 210604 | Урсгал засвар | 1,315,700 | 00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 250,000 | 00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 250,000 | 00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,220,000 | 12,821,100 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000 | 3,971,100 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000 | 00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00 | 8,850,000 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 124,187,329 | 159,439,541 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,164,024 | 35,985,954 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,013,550 | 13,256,800 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 114,009,755 | 110,196,787 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 58,206,968 | 72,828,510 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 46,399,463 | 72,828,510 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,085,627 | 72,828,510 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 18,313,836 | 00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 10,828,581 | 00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,828,581 | 00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 978,924 | 00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 978,924 | 00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -89,799,509 | 14,027,827 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 2,336,408 | 00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,336,408 | 00 |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-2,336,408** | **00** |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-92,135,917** | **14,027,827** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,329,584,010** | **1,721,615,899** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 5,411,100 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 5,411,100 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 5,411,100 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 3,971,100 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 1,440,000 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,329,584,010** | **1,716,204,799** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,148,828,000 | 1,410,444,500 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 1,410,444,500 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,148,828,000 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 31,119,710 | 4,246,699 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,230,999 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,000,000 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,888,711 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 4,246,699 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 149,636,300 | 301,513,600 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 149,636,300 | 301,513,600 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,330,209,610** | **1,719,425,842** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,330,209,610** | **1,719,425,842** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,269,821,793 | 1,643,310,342 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 934,231,821 | 1,087,914,850 |
| 210101 | Үндсэн цалин | 626,285,521 | 785,425,795 |
| 210102 | Нэмэгдэл | 254,117,300 | 261,279,696 |
| 210104 | Урамшуулал | 53,829,000 | 41,209,358 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 122,941,610 | 136,356,879 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,817,545 | 92,573,600 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,372,400 | 10,793,500 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,497,900 | 8,801,164 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,841,568 | 2,178,200 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,412,197 | 22,010,415 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 147,341,676 | 242,906,000 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,660,876 | 9,009,600 |
| 210302 | Түлш, халаалт | 138,311,000 | 232,396,400 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 369,800 | 1,500,000 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,741,436 | |
| 210401 | Бичиг хэрэг | 585,800 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 850,580 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 25,000 | |
| 210404 | Ном, хэвлэл | 142,750 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,296,006 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,841,300 | |
| 2105 | Нормативт зардал | 28,420,832 | 61,281,900 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 120,000 | |
| 210502 | Хоол, хүнс | 25,350,690 | 61,281,900 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,950,142 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,315,700 | 3,815,700 |
| 210604 | Урсгал засвар | 1,315,700 | 3,815,700 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 250,000 | |
| 210702 | Дотоод албан томилолт | 250,000 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,220,000 | 12,821,100 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000 | 3,971,100 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 8,850,000 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,358,718 | 98,213,914 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,095,000 | 83,372,339 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,263,718 | 14,841,575 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 60,387,817 | 76,115,500 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 48,580,312 | 76,115,500 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,266,476 | 76,115,500 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 18,313,836 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 10,828,581 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,828,581 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 978,924 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 978,924 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | -625,600 | 2,190,057 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | -625,600 | 2,190,057 |

| | | | |
|---|---|---|---|
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0** | **-** |
| 31 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **2,190,057** |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,251,839,958 | 977,980,202 | -554,764,274 | 00 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | -66,297,374 | -66,297,374 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,251,839,958 | 977,980,202 | -621,061,648 | 1,608,758,512 |
| 4 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 15,962,000 | 00 | 00 | 15,962,000 |
| 5 | Тайлант үеийн үр дүн | 00 | 00 | -92,135,817 | -92,135,817 |
| 6 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,267,801,958 | 977,980,202 | -713,197,465 | 1,532,584,695 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | 14,027,827 | 14,027,827 |
| 8 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,267,801,958 | 977,980,202 | -699,169,638 | 1,546,612,521 |

## 2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | % |
|---|---|---|---|---|---|
| - | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - | - | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,711,958,100** | **1,719,425,842** | **-7,467,742** | 100 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,711,958,100 | 1,719,425,842 | -7,467,742 | 100 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,635,842,600 | 1,643,310,342 | -7,467,742 | 100 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,089,099,100 | 1,087,914,850 | 1,184,250 | 100 |
| 210101 | Үндсэн цалин | 838,568,800 | 785,425,795 | 53,143,005 | 94 |
| 210102 | Нэмэгдэл | 222,731,800 | 261,279,696 | -38,547,896 | 117 |
| 210104 | Урамшуулал | 27,798,500 | 41,209,358 | -13,410,858 | 148 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 136,024,500 | 136,356,879 | -332,379 | 100 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 92,573,600 | 92,573,600 | | 100 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,793,500 | 10,793,500 | | 100 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,697,300 | 8,801,164 | -103,864 | 101 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,178,200 | 2,178,200 | 00 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,781,900 | 22,010,415 | -228,515 | 101 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 242,906,000 | 242,906,000 | 00 | 100 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,009,600 | 9,009,600 | 00 | 100 |
| 210302 | Түлш, халаалт | 232,396,400 | 232,396,400 | 00 | 100 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000 | 1,500,000 | 00 | 100 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 00 | 00 | 00 | |
| 2105 | Нормативт зардал | 61,281,900 | 61,281,900 | 00 | 100 |
| 210502 | Хоол, хүнс | 61,281,900 | 61,281,900 | 00 | 100 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,815,700 | 3,815,700 | 00 | 100 |
| 210604 | Урсгал засвар | 3,815,700 | 3,815,700 | 00 | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,900,300 | 12,821,100 | -2,920,800 | 130 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00 | 3,971,100 | -3,971,100 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,900,300 | 8,850,000 | 1,050,300 | 89 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 92,815,100 | 98,213,914 | -5,398,814 | 106 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 77,964,700 | 83,372,339 | -5,407,639 | 107 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,850,400 | 14,841,575 | 8,825 | 100 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 76,115,500 | 76,115,500 | 00 | 100 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 76,115,500 | 76,115,500 | 00 | 100 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 76,115,500 | 76,115,500 | 00 | 100 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | 00 | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,711,958,100 | 1,721,615,899 | -9,657,799 | 101 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,410,444,500 | 1,414,691,199 | -4,246,699 | 100 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,410,444,500 | 1,410,444,500 | 00 | 100 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 00 | 4,246,699 | -4,246,699 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00 | 4,246,699 | -4,246,699 | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 301,513,600 | 301,513,600 | | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 301,513,600 | 301,513,600 | | 100 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | | 5,411,100 | -5,411,100 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 3,971,100 | -3,971,100 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 1,440,000 | -1,440,000 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 2,190,057 | -2,190,057 | |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | | |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 77 | 77 | | |
| 24 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 77 | 77 | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Манхан сумын сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилготойгоор 77 ажилтан албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулсан байна.

Танхимаар тасралтгүй 33-34 долоо хоног хичээллэж, сургуульд суурилсан үнэлгээ улсын хэмжээнд анх удаа хийгдэж 4 багшийн заасан хичээл I-III түвшинд үнэлэгдэж сарын 10%-25% урамшуулал авсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан бөгөөд шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгасан байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Манхан сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.5 сая төгрөгөөр буюу 101.1 хувиар өссөн байна. Өмнөх оноос мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэлд өөрчлөлт орсон байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 2.2 | 2.2 |
| Авлага | 15.8 | 0 | -15.8 |
| Бараа материал | 143.9 | 147.8 | 3.9 |
| Үндсэн хөрөнгө | 1372.8 | 1400.0 | 27.2 |
| **Нийт хөрөнгө** | **1532.5** | **1550.0** | **17.5** |
| Өр төлбөр | - | 3.5 | 3.5 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1532.6 | 1546.6 | 14.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1532.5** | **1550.0** | **17.5** |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Оны эцсийн авлагыг барагдуулж 15.8 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө болон бараа материалын дансанд хөрөнгийг бүртгэн авсан
- ✓ Бараа материал 3.9 сая төгрөгийн түрээсийн номын орлогоор нэмэгдсэн.
- ✓ Үндсэн хөрөнгөд журмын дагуу авсан тоног төхөөрөмж болон авлаг барагдуулан авсан тоног төхөөрөмж мөн хандиваар ирсэн тоног төхөөрөмж, БШУЯ-наас шилжүүлэн авсан хөрөнгүүдээр өсөж элэгдлээр хасагдан нийт 27.2 сая төгрөгөөр өссөн.
- ✓ Өр төлбөр бараа материал болон цахилгааны төлбөрөөр нийт 3.5 сая төгрөгөөр өссөн

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Манхан сумын сургууль нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1158.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,158.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Орон нутгийн төсвөөс сумын ИТХ-д 301,5 сая төгрөгийн төсвийн санал хүргүүлж үлй ажиллагаагаа санхүүжүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 1158.9 сая төгрөгөөр батлан иргүүлж, тайлант хугацаанд төсвийн тодотгол хоёр удаа хийгдэж 1410.5 сая төгрөг болж 251.6 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,410.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 301.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,410.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 301.5 сая төгрөгийн 100% санхүүжилт авч зарцуулсан мөн өмнөх оны дансны үлдэгдэл 2.5 сая төгрөг, дээд шатны захирагчийн хуваарилсан 1,4 сая төгрөг, өөрийн орлого 1.7 сая төгрөгийг нэмж зарцуулан төсвийн зарцуулалт 100% гарсан.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/сая төгрөг/

| Код | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 80111 | Барилгын тогтмол зардал | 246.72 | 246.72 | - | 100% |
| 80113 | Нийтлэг үйлчилгээ | 54.79 | 54.79 | - | 100% |
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 3.96 | 3.96 | - | 100% |
| 80312 | Сургалт семинар | 1.98 | 1.98 | - | 100% |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 4.55 | 4.55 | - | 100% |
| 81801 | Үдийн цай хөтөлбөр | 76.12 | 76.12 | - | 100% |
| 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 108.8 | 108.8 | - | 100% |
| 81816 | Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 50.95 | 50.67 | 0.28 | 99% |
| 81823 | Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 8.91 | 8.91 | - | 100% |
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр | 1,032.21 | 1,031.14 | 1.07 | 99% |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 122.92 | 122.08 | 0.84 | 99.3% |
| 81844 | Гүнзгийрүүлсэн болон сургалтын орчныг сайжруулах | 1.7 | 1.7 | - | 100% |
| 81848 | Сурах бичгийн түрээс | 3.97 | 3.97 | - | 100% |
| 83601 | Нэмэлт-Олон улсын байгуулгаас олгосон | 2.5 | 2.5 | - | 100% |
| 83602 | ЗД-н нөөц хөрөнгөөс хувиарласан | 1.4 | 1.4 | - | 100% |
| | **дүн** | **1721.52** | **1719.34** | **2.19** | **1412%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд

аймгийн Манхан сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамаарах дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хоо өрлөгийн үрс аудит ХХК-ны аудитор А.Оюундэлгэр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Манхан сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1340.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 26.8 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн тайлангийн нийт орлого 1799.0 сая төгрөгөөр 2 хувиар буюу 36.0 сая төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцон 28.7 сая төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоосон болно.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор зардлыг хасаж тодотгоогүй, аудитаар төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон арга хэмжээг санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн оруулж 157 мэдээг хугацаанд мэдээлсэн байна. Хугацаа хоцорсон мэдээ байхгүй, хуулийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 1,6 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.

### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Зөрчилгүй" санал дүгнэлт авч шилжүүлсэн байна. Аудитын шийдвэрийн нийт биелэлт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Илрүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 4 | 21,4 | 4 | 21.4 | 100 |
| **Нийт дүн** | **4** | 21,4 | 4 | 21.4 | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар  оны эцэст салбарын зохион байгуулдаг худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5.0 сая төгрөгийн алдаа[1], Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 1.6 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.Санхүүжилт хооронд гүйлгэн тайлагнасан 1.4 сая төгрөгийн залруулга хийж, төсвийг зориулалт бусар зарцуулсан  2.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

**5:1 Залруулга :** Мөнгөн хөрөнгийн журналыг тайлангийн санхүүжилттэй тулган шалгахад улсын төсвийн санхүүжилт 1440000 төгрөгөөр илүү бусад орлогоос гүйлгэн тооцсон тусгасныг Нягтлан бодох бүртгэлийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна гэсэн заалтыг үндэслэн залруулга хийв.

5.3 Зөвлөмж

***5.3.Хуулийн хэрэгжилттэй  холбоотой***

***Илрүүлэлт:*** " Захирлын 2022.05.18-ны өдрийн А/12 тоот тушаалаар 298000 төгрөг, 2022.05.20А/14 тоот тушаалаар 221800,2022.06.16-ны А/20 тушаалаар 822000 төгрөг2022.11.01-ний өдрийн А/41 тоот тушаалаар 240000 төгрөг шагнал урамшуулал,  Засаг даргын 2022.05.23-ны өдрийн А/83 тоот захирамжаар  бэлэг  450000 төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д Төсвийг зориулалтын дагуу зарцуулна  гэсэн заалтай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж*** *:Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

[1]Тайлагнасан санхүүгийнтайлангийнүзүүлэлт, тайлагнасанбайвалзохихүзүүлэлтийнхоорондынзөрүү. Мэдээллийгтусгахгүйорхигдуулах, буруутусганилэрхийлэх, үүнд, математикүйлдлийналдаа, НББ-ийнбодлогыгмөрдөхөдгарсаналдаа, бодитбайдлыгбуруутайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүйорхисон/,

/ сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Улсын төсвийн санхүүжилт илүү бусад орлогоос гүйлгэн тусгасан | 1 | 1,4 | | | 1 | 1.4 | 1 | 1.4 | | | | |
| Төсвийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 2.0 | | | | | | | | | 1 | 2.0 |
| **Дүн** | **2** | **3.4** | | | **1** | **1.4** | **1** | **1.4** | | | **1** | **2.0** |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

ХО ӨРЛӨГИЙН ҮРС АЖДИТ ХХК-НЫ

АУДИТОР: А.ОЮУНДЭЛГЭР